



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 31 өдөр

Дугаар 41252.

Улаанбаатар хот

“Баянзүрх дүүргийн 255 дугаар цэцэрлэгийн” эргэлтийн бус хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 13 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 4,795,791.0 (дөрвөн сая долоон зуун ерэн таван мянга долоон зуун ерэн нэг) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтын дагуу Баянзүрх дүүргийн 21, 301, 337 дугаар цэцэрлэг, Нийслэлийн ерөнхий боловсролын 33 дугаар сургуулийн балансад тус, тус шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Баянзүрх дүүргийн 255 дугаар цэцэрлэг (Г.Цэцгээ)-т зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 33 дугаар сургууль (Н.Энхбат), 21 дүгээр цэцэрлэг (Т.Заяа), 301 дүгээр цэцэрлэг (О.Оюунмаа), 337 дугаар цэцэрлэг (Л.Нарангэрэл)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс /Г.Тэмүүжин/-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

1150502120

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын
даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний
өдрийн А/152 дугаар тушаалын хавсралт

Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянзүрх дүүргийн 255 дугаар цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэн авах байгууллага
1	Хөргөгч /4 хаалгатай/	Орос	2024.12.03	ш	1	1,320,000.00	1,320,000.00	36,666.67	1,283,333.33	Баянзүрх дүүргийн 256 дугаар цэцэрлэг
2	Хөргөгч /дээжний/	Хятад	2024.12.03	ш	1	176,000.00	176,000.00	4,888.89	171,111.11	
	шилжүүлэх эд хөрөнгийн дүн						1,496,000.00	41,555.56	1,454,444.44	
1	Хүүхдийн сандал	Монгол	2024.12.03	ш	30	13,648.00	409,440.00	6,824.00	402,616.00	Баянзүрх дүүргийн 304 дүгээр цэцэрлэг
2	Самбар	Хятад	2024.12.03	ш	1	59,337.00	59,337.00	988.95	58,348.05	
	Шилжүүлэх хөрөнгийн дүн						468,777.00	7,812.95	460,964.05	
1	Агаар шүүгч /GHMN-180605/	Хятад	2024.12.03	ш	1	285,714.00	285,714.00	7,936.50	277,777.50	
2	Агаар шүүгч /GHMN-180619/	Хятад	2024.12.03	ш	1	285,714.00	285,714.00	7,936.50	277,777.50	
3	Агаар шүүгч /GHMN-180639/	Хятад	2024.12.03	ш	1	285,714.00	285,714.00	7,936.50	277,777.50	Баянзүрх дүүргийн 311 дүгээр цэцэрлэг
4	Агаар шүүгч /GHMN-180542/	Хятад	2024.12.03	ш	1	285,714.00	285,714.00	7,936.50	277,777.50	
5	Вандан сандал	Монгол	2024.12.03	ш	4	35,602.00	142,408.00	2,373.47	140,034.53	
6	Сандал /хуванцар/	Хятад	2024.12.03	ш	76	10,250.00	779,000.00	12,983.33	766,016.67	
	Шилжүүлэх эд хөрөнгийн дүн						2,064,264.00	47,102.80	2,017,161.20	
1	Жин /300кг -гал тогоонд/	Хятад	2024.12.03	ш	1	117,750.00	117,750.00	3,270.83	114,479.17	Баянзүрх дүүргийн 321 дүгээр цэцэрлэг
2	Хөргөгч /2 хаалгатай/	Хятад	2024.12.03	ш	1	649,000.00	649,000.00	18,027.78	630,972.22	
	Шилжүүлэх хөрөнгийн дүн						766,750.00	21,298.61	745,451.39	
	Нийт шилжүүлэх эд хөрөнгийн дүн						4,795,791.00	117,769.92	4,678,021.08	